

ONE WORLD FESTA 2018

by Togtokhtur Batbold

- 12 Dec 2018 -

The “One World Festa in Iwate” is an annual event held place here in Morioka at the Aina Center near Morioka Station. Its goal is to exhibit as many different countries’ cultures as possible and to encourage and celebrate the diversity of nations and their people. Anyone, from international to Japanese citizens can volunteer and help in the event. While I was unable to participate before, I was given the opportunity to volunteer in and witness it this year.



<Indonesian story-telling >

A staggering number of wide ranging visitors could be seen at the event. Students from our very own Iwate University as well as Iwate Prefectural University students, scouts, tourists, teachers and working people were all welcomed.

Children and young students seemed to have the most fun at their own kids’ corner and could also partake in face painting, rugby goal kicking, trying out Google Earth through a VR headset, and watching cartoons at a miniature recreation of an old US cinema.

Volunteers were dressed in their own colorful, traditional clothing and adorned their booths with dazzling displays. For our part, we introduced brain-stimulating Mongolian puzzle games and found that the children were, to our delight, quite keen to solve.



<World Area>

The event was held on the 8th, over 2 floors, with the center piece being the World Area where, surrounding a giant electronic tree, nationals from 28 countries in Asia, Europe, the Americas and Oceania branched out and set up booths to showcase their cultures. It opened with a large crowd of visitors unanimously performing New Zealand’s haka driving and setting off the event with energy and vigour. Visitors could take part in various games and activities and watch performances including, but not limited to, Philippine dancing, Cuban games and Indonesian story telling. Japanese culture was also on display, letting foreigners try their hand at calligraphy and origami.



<Mongolian Booth>

The event was incredibly wholesome and it was a delightful and fun experience to take part in. I trust more people will participate in the coming years to enrich and make the event even more impressive. I for one, hope to participate once again at next year’s event.



<British and Chinese booths>

“НЭГ ДЭЛХИЙ” НААДАМ 2018

Батболд Тогтохтөр

- 2018/12/12 -

“One World Festa - in Iwate”, буюу Иватэ дахь “Нэг Дэлхий” наадам нь Мориокагийн Аина төвд жил бүр зохион байгуулагддаг баяр юм. Энэхүү арга хэмжээний эрхэм зорилго нь аль болох олон улсын соёл уламжлалыг япон болон олон улсын зочдод танилцуулан, орон бүрийн өвөрмөц шинж чанарыг дэмжин түгээх юм. Энэхүү арга хэмжээнд зөвхөн Япон биш, хаанаас ч ирсэн олон улсын иргэд сайн дураар оролцон туслах боломжтой. Би хувьдаа өмнөх жилд орж чадаагүй ч, энэ жил орж үзэх завшаан гарсан юм.



<Индонези үлгэр сонсож буй зочид>

Иватэ Их Сургууль, мөн Иватэ Мужийн Их Сургуулийн оюутан нар, скаут, жуулчид, багш нар мөн жирийн иргэд зэрэг олон тооны хүмүүс арга хэмжээг үзэхээр ирсэн юм.

Хүүхдүүдэд зориулж хүүхдийн тусгай буланг гаргасан ба нүүр будалт, рагби хөл бөмбөг тоглох, виртуал төхөөрөмж ашиглах, мөн хүүхэлдэйн кино үзэх зэрэг сонирхол татахуйц зүйлс ихээр байсан нь хүүхдүүдийг ихээр баярлуулж чадсан юм. Оролцогчид өөрсдийн орныхоо уламжлалт хувцас өмсөн үзүүлэнгүүдээ өнгөлөгөөр чимснээр гайхалтай орчин бүрдүүлж чадсан юм.

Бидний хувьд Монгол соёл дотроо тархи хөгжүүлэх оньсон тоглоомыг танилцуулсан ба хүүхэд сурагчид ихээр сонирхон тоглоомыг тайлахыг оролдсон болно.



<Монгол үзүүлэн>

Арга хэмжээ нь маш сонирхолтой байсан ба амжилттайгаар өрнөсөн. Ирэх жилүүдэд илүү олон хүмүүс оролцон, үйл ажиллагааг улам баяжуулж илүү гайхалтай болгоно гэж бид найдаж байна. Би хувьдаа дараа жил дахин оролцоход таатай байх болно.



<Дэлхийн Бүс>

Уг арга хэмжээ нь энэ сарын 8-нд Аина төвийн 4, 5 давхарт болсон ба гол үзмэрээр “World Area” буюу “Дэлхийн Бүс” хэмээх хэсэг нь олныг хамгаар татсан. Энэхүү хэсэгт Ази, Европ, Америкийн 28 орны иргэд өөрсдийн орныг танилцуулсан үзүүлэнгүүдийг босгон тавьсан болно. Арга хэмжээг Шинэ Зеландын Хака ёслолоор нээсэн бөгөөд үүнд оролцогчдыг хамруулснаар наадмыг чангаар, эрчимтэйгээр эхлүүлж чадсан юм. Зочид нь Филиппин бүжиг үзэж, Куба тоглоом тоглон, мөн Индонези үлгэр сонсох зэрэг төрөл бүрийн хөгжөөнд оролцсон. Мөн Японы соёлыг сонирхсон хүмүүст уран бичлэг, оригами урлаг зэргийг турших боломж гарсан.



<Британи болон Хятадын үзүүлэн>